

## **НЭГДСЭН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

### **Асуулт, санал: Доктор Ц.Цэрэндорж**

Юуны өмнө энэ хурлыг эрдэм шинжилгээний хурал гэж ойлгож байгаа учраас үүнтэй холбогдуулан дараах хэдэн саналыг хэлье.

Нэгдүгээрт, нэр томъёоны асуудлыг анхаараач гэж хүсэж байна. Зарим нь гэрээ, зарим нь хэлэлцээр гэж яриад байна. Мөн хэлэлцээр, хэлэлцээ ч гэж ярьж байна. ХЭЛЭЛЦЭЭ гэдэг хоорондоо хэлэлцэх үйл явцыг хэлдэг, бичиг баримт биш. Нэр томъёогоо цэгцлэхгүй бол сүүлд нь хоёр өөр юм яриад байгаа юм шиг асуудалд ордог.

Хоёрдугаарт, зарим илтгэлийн сэдэв, агуулга хоёр зөрсөн тал харагдаад байна. Жишээлбэл, зарим илтгэл сэдвийг нь харахаар 1950-аад оны тухай юм шиг, гэтэл илтгэлд нь 1960-аад оны үеийн мэдээлэл орчихсон, ярьж байгаа юм нь 1950, 60-аад оны тухай болчихоод байна. Энэ талыг анхаарах ёстой юм болов уу.

Гуравдугаарт, Монголын хүн амын тоог 1950-аад онд 600 мянга байсан гээд хэлчих шиг боллоо. 1944 оны тооллогоор Монголын хүн ам 759100 байсан, 1956 оны тооллогоор 845500 байсан. Тэгэхлээр 1952 оны үед 800 гаруй мянга байсан байж таарна. Монгол талын суурь өгөгдөл, ойлголтуудаа зөв байлгах тал дээр их анхаарах хэрэгтэй байна. Мөн судалгаандаа Хятадын талын байр суурийг ч анхаарч байхгүй бол дүгнэлт өрөөсгөл болох бий гэсэн болгоомжлол байна.

### **Хариулт: Доктор Д.Баярхүү**

ХЭЛЭЛЦЭЭР бол хоёр улсын харилцаанд байгуулдаг эрх зүйн баримт бичиг. 1952 онд байгуулсан хэлэлцээр бол олон улсын эрх зүйн баримт бичиг мөн. Тэгэхээр хэлэлцээрийнхээ ойг тэмдэглэж байна. Гэхдээ хэлэлцээрт хүрэхийн тулд хоёр талын Гадаад явдлын яамны хооронд ХЭЛЭЛЦЭЭ явагдсан. Хэлэлцээг баяжуулаад яриа хэлэлцээ гэж хоршиж хэрэглэдэг. Хэлэлцээ гэдэг маань орос хэлэнд Переговор, англи хэлэнд Talk, Negotiation юм. Харин ХЭЛЭЛЦЭЭР буюу гарын үсэг зурдаг баримт бичиг нь орос хэлэнд Соглашение, англи хэлний Agreement болно. Дахиад гэрээ гэж байна. Бас л эрх зүйн баримт бичиг. Гэхдээ гэрээ, хэлэлцээр хоёрыг ярихад гэрээ нь дээгүүр тавигддаг. Хоёр улсын Найрамдал, хамтын ажиллагааны тухай гэрээ, Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ эсвэл Хилийн тухай гэрээ гэх мэтээр агуулга, ач холбогдол өндөр болчихдог.

Хоёр талын харилцаанд Харилцан ойлголцох санамж бичиг буюу Memorandum гэж байна. Хоёр талын эсвэл олон талт байж болдог. Гэрээ, хэлэлцээр зэрэг эрх зүйн баримт бичгүүд зөвхөн хоёр талт биш олон талт ч байдаг. Олон улсын хамтын ажиллагааны олон талт гэрээнүүд байдаг, дөрвөн

талт гэх мэт. Бас зайлшгүй дагаж мөрдөх өөр баримт бичиг Тунхаглал гэж байна. Жишээлбэл, 2014 онд Ши Жиньпин дарга айлчлах үеэр Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн хамтаар “Иж бүрэн стратегийн түншлэл байгуулах тунхаглал”-д гарын үсэг зурсан. Эдгээрийг жинхэнэ андуурч, хольж ярьдаг хүмүүс бол манай хэвлэл мэдээллийнхэн сэтгүүлчид, олон улсын харилцаанд тэр болгон оролцоод байдаггүй улс төрчид юм.

**Асуулт: Доктор Б.Энхчимэг**

1949 оны 10 дугаар сарын 1-нд БНХАУ байгуулагдсаны дараа БНМАУ-ын Ерөнхий сайд, Гадаад хэргийн сайд маршал Х.Чойбалсан 10 дугаар сарын 6-нд БНХАУ-ын Гадаад хэргийн сайд Жоу Энълайд албан бичиг илгээсэн. Энэ албан бичигт БНМАУ нь БНХАУ-ыг хүлээн зөвшөөрч байгааг илэрхийлж, шинэ Хятад улстай дипломат харилцаа тогтоох, харилцаа хөгжүүлэх, элчин төлөөлөгчөө солилцох хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн байдаг. 10 дугаар сарын 16-нд Жоу Энълай хариу захидал илгээсэн байдаг. Захидалдаа энэ албан бичгийн утгыг давтаад БНМАУ-ын Ерөнхий сайд Х.Чойбалсангийн саналыг хүлээн авч машинд баярлаж байгаагаа илэрхийлсэн байна. Гэхдээ энд дипломат харилцаа тогтооё, ноот бичиг солилцъё гэсэн үг өгүүлбэр байхгүй. Манай улс 1949 оны 10 дугаар сарын 16-нд дипломат харилцаа тогтоосон гэж үздэг. Энэ талаар Хятадын тал яг юу гэж үздэг вэ? Энэ талаарх ноот бичиг байдаг болов уу?

**Хариулт: Доктор Д.Базардорж**

Монгол-Хятад хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосон нь яг хэдний өдөр вэ гэдэг нь маргаантай явсаар ирсэн юм билээ. 1959 онд хоёр улс харилцаа тогтоосныхоо 10 жилийн ойг тэмдэглэх болоход манай улс Х.Чойбалсангийн явуулсан бичгийн огноог баримтлан 10 дугаар сарын 6-нд гээд тогтчихсон байсан, харин Хятадын тал болохоор хариу ирүүлсэн өдрөө үндэс болгоод 10 хоногийн зөрүүтэйгээр тогтчихсон байснаа харилцан мэдэлцсэн юм билээ. Талууд яг ийм ойлголтын зөрүүтэйгээр бүхэл бүтэн 10 жил яваад байж. Тиймээс хоёр талаас нааш цааш харилцан ярилцсаны эцэст, найрамдалт харилцаа, ах дүүгийн харилцааг бодолцон харилцан найр тавилцаж, ялангуяа манай талаас буулт хийж байж. Ингэж л хоёр тал албан ёсоор дипломат харилцаа тогтоосон өдрийг 10 дугаар сарын 16-ны өдөр гэж хэзээ хойно арван жилийн дараа албажуулж байсан юм билээ.

**Асуулт: Доктор Б.Энхчимэг**

1946 оны 1 дүгээр сарын 5-нд ДИУ БНМАУ-ын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрснөө албан ёсоор зарласан. Гэтэл ЗХУ-БНХАУ хоёр гэрээг шинэчлэн байгуулахдаа нэрийг өөрчлөлгүй, агуулгыг нь өөрчилсөн байдаг. Гэрээн дээр

“БНМАУ-ын тусгаар тогтнолын санал хураалтыг үндэслэн тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрч байна” гэсэн заалтыг Жоу Энълай оруулсан байдаг. Тэгэхээр 1949 оны 10 дугаар сарын 16-нд дипломат харилцаа тогтоосон гэсэн мөртөө жилийн дараа ийм асуудал гаргаж ирсэн нь зөрчилтэй санагдаж байна.

**Хариулт: Доктор Д.Базардорж**

1950 оны «ЗХУ-БНХАУ-ын Найрамдал холбоо, харилцан туслалцах гэрээ» байгуулагдсан өдөртэй зэрэгцээд хоёр улсын Гадаад харилцааны яам Монголын асуудлаар ноот бичиг гаргасан байдаг. Ноот бичгийн Нэгдүгээр зүйл нь 1945 оны Монголын бүх ард түмний тусгаар тогтнолын төлөөх санал хураалтын асуудал, Хоёрдугаар зүйл нь 1949 онд Монгол-Хятад хоёр улс дипломат харилцаа тогтоосон явдал юм. Эдгээр нь БНМАУ-ын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөх түүхэн үндэслэл мөн гэдэг амлалтыг БНХАУ-ын талаас гаргаж тавьсан.

**Доктор Д.Баярхүү:** Тайваньд суралцаж байгаа, Тайваньд эрдмийн зэрэг хамгаалж байгаа, Тайваньд архивд сууж судалгаа хийж байгаа манай эрдэмтэд нэг зүйлийг анхаарах хэрэгтэй санагддаг. 1949 оны 10 дугаар сарын 1-нд БНХАУ тунхагласны дараа түүнтэй дипломат харилцаа тогтооход ЗХУ ч, БНМАУ ч ДИУ-аас дипломат харилцаагаа таслаад БНХАУ-тай дипломат харилцаа тогтоолоо гэсэн албан ёсны шийдвэр ба тэгж зарлан тунхагласан явдал байдаггүй юм. Тэгэхлээр, 1954 он хүртэл Хятадын хоёр улстай зэрэг дипломат харилцаатай явсан байдаг. Энэ бол олон улсын харилцаанд гарсан сонин үйл явдал. Он дарааллаар авч үзвэл Монгол нь Зөвлөлт Орос Улстай 1921 онд, ДИУ-тай 1946 онд, БНАСАУ-тай 1948 онд, дараа нь БНХАУ-тай харилцаа тогтоосон. Тэгэхээр Тайвань руу гарсан ДИУ-ын тэвчээр барагдаж, 1945 оны ЗХУ-тай байгуулсан «Найрамдал, холбооны тухай гэрээ»-гээ цуцалсан байдаг. Цуцалсантай холбогдуулан 1945 оны 8 дугаар сарын 14-нд Москвад тохиролцсон тэр гэрээнийх нь хавсралт дахь “БНМАУ-ын тусгаар тогтнолыг бүх ард түмнийх нь санал хураалтаар шийднэ” гэдэг заалт хүчингүй болчихсон юм. Тиймээс л 1954 оноос Тайваньд байдаг ДИУ-ын албан ёсны түүхэн сурах бичигт манай хилийг өөртөө багтаан оруулж зураад, хойд хилээ Саяны нуруу, Хэнтий нуруу, Алтай нуруугаар хойшоо Байгаль нуур хүргэн зурж хадуураад байх болсон нь үүнээс эхтэй. Тухайн үед олон улсын харилцаанд ийм өвөрмөц үйл явдал болж байжээ гэдгийг манай эрдэмтэд анхаарч байх хэрэгтэй юм л даа.

**Асуулт: Доктор Т.Чулуун-Эрдэнэ**

Х.Баатархүү судлаачаас асууя. Монголын Засгийн газар хятад ажилчдыг оруулж ирэхдээ түр оршин суух бус, харин байнга оршин суух зөвшөөрөл олгох шийдвэр гаргасан талаарх материалыг олж уншсан юм. Тэгэхлээр

1963 оноос Монгол-Хятадын харилцаа муудахад Хятад улс ажилчдаа татахад Монголд байнга оршин суухаар үлдсэн хятад ажилчид байдаг уу? тэдний тоо хэд вэ, архивд баримт буй болов уу?

**Хариулт: Х.Баатархүү**

Давхардсан тоогоор 23680 орчим, ар гэрийн хүмүүсийн хувьд 6400 орчим, нийт 30 мянга орчим хятад ажилчид Монголын социалист бүтээн байгуулалтад оролцжээ. 1958, 1959 онд хоёр жил дараалан Монголын иргэн болгох үйл явц нэлээд идэвхжиж байсан. Тухайлбал, нэг удаагийн зарлигаар л 158 хүн, дараа нь 120 орчим хүн гэх мэтээр Монголын иргэн болгож байж. 1963 оноос харилцаа хүйтрээд 1964 онд хэрэгжиж байгаа төслүүдийг үргэлжлүүлж бусад шаардлагагүй эсвэл тохиролцсон ч хараахан хэрэгжүүлж эхлээгүй байсан төслүүдийг зогсоосноор ажилчид буцсан, тэгэхэд 1964 онд 100 хүрэхгүй хүн л үлдсэн, харин 1973 онд хамгийн сүүлчийн 7 хүн буцсан байдаг. Энэ талаарх тун тодорхой тоо баримттай баримтууд архивд байдаг. Харин 1960-аад оноос 1958, 59 оных шиг олон тоогоор Монголын иргэн болгодог байсан үйл явдлыг таслан зогсоосон байдаг.

Нэмж хэлэхэд, 1951 оноос эхлэн БНХАУ-ын талд ажилчин авах саналыг манай талаас тавьсан. Тэгэхэд Хятадууд эхэндээ татгалзаж байсан нь тухайн үед өрнөж байсан Солонгосын дайнтай холбоотой байж. Харин МАХН-ын XIV их хуралд оролцохоор ирсэн БНХАУ-ын Ерөнхий сайдын орлогч бөгөөд Төв хорооны орлогч гишүүн Улаанхүү ба Элчин сайд Хө Ин нарт Монголын талын удирдагчидтай уулзах үедээ ажиллах хүчээр туслах хүсэлтэд Хятадын тал зөвшөөрч байгааг дамжуулан илэрхийлүүлсэн байдаг. Энэ асуудалд Монголын тал үргэлж хэл соёл нэгт Өвөр Монголоос хүмүүс авах хүсэлтийг тавьдаг байсан ч Хятадын тал үүнд татгалзаж байжээ. Ерөнхийдөө, Монгол дахь хятад ажилчид Хятадын Зүүн хойд гурван мужаас голчлон ирдэг байв. Харин Өвөр Монголоос харьцангуй цөөхөн байсан юм.

**Доктор Д.Шүрхүү:**

Хурал их сонирхолтой байв. Хурлын эмхэтгэл ч хэвлэгдэн гарах байх, эмхэтгэлийг илүү их сонирхолтой, ач холбогдол өндөртэй байлгах үүднээс хэлэх санал байна. Бид нар голдуу үр дүнг л яриад байна. Гэтэл хэлэлцээр байгуулах үеийн үйл явц гэдэг бол их сонирхууштай, анхаарууштай, өгүүлэмж ихтэй байдаг. Тэндээс тухайн нөхцөл байдал тод харагддаг, нарийн ширийн асуудлууд анзаарагддаг л даа. Ийм агуулга бүхий архивын баримтууд, уулзалтуудын тэмдэглэл, биеэр оролцогчдын дурсамж яриа зэргээс Гадаад яамны архивд байгаа эх материалуудаас шигтгэж оруулбал сонирхолтой болно. Залуу судлаачдад их хэрэгтэй, эрдэм шинжилгээний үнэ цэн нь ч сайн болох талтай байдаг юм шүү.